

СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1. Судалгааны их сургуулийн чиг үүрэг, тавих шалгуур, шаардлага, судалгааны их сургуулийн бие даасан байдал, түүний баталгааг бүрдүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулна.

2 дугаар зүйл. Судалгааны их сургуулийн тухай хууль тогтоомж

2.1. Судалгааны их сургуулийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Судалгааны их сургуулийн үйл ажиллагааны зарчим

- 3.1. ил тод, нээлттэй байх;
- 3.2. ашиг сонирхолын зөрчлөөс ангид байх;
- 3.3 судалгаа, эрдэм шинжилгээний ёс зүйг сахих;
- 3.4. судалгаа нь үр дүнтэй, хэрэгжихүйц байх.
- 3.5. шударга өрсөлдөөнийг эрхэмлэж, манлайлах

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд ашигласан зарим нэр томъёог доор дурдсан агуулгаар ойлгоно.

4.1.1. “судалгааны их сургууль” гэж эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын чанараар тэргүүлэх, улс төрөөс хараат бус, эрдмийн эрх чөлөө, санхүүжилтийн тогтвортой эх үүсвэртэй, ашгийн төлөө бус, дээд боловсролын эрдэм шинжилгээ-сургалтын байгууллагыг;

4.1.2. “санхүүжилтийн тогтвортой эх үүсвэр” гэж улсын болон орон нутгийн төсөв, хувийн хэвшил, олон улсын байгууллага, сан, хандив, оюуны өмчийн роялти, судалгааны тэтгэлэг, сургалтын төлбөр, их сургуулийн өөрийн орлого болон хуулиар зөвшөөрсөн бусад эх үүсвэрийг;

4.1.3. “интерншип” гэж ахисан түвшний суралцагч (магистрант, докторант)-ийн мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, сургалт- үйлдвэрлэлийн уялдаа холбоог бэхжүүлэхэд чиглэсэн мэргэшүүлэх дадлагын тогтолцоог,

4.1.4. “ассистантшип” гэж ахисан түвшний суралцагч (магистрант, докторант)-ийн эрдэм шинжилгээний ур чадварыг хөгжүүлэх, гүнзгийрүүлэн суралцахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд профессор тусалж хамтран ажиллах суралцагчийг;

4.1.5. “докторын дараах судалгаа” гэж тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд хийгдэж буй ахисан түвшний судалгааг,

4.1.6. “хамтарсан төсөл” гэж нэг талаас судалгааны их сургууль, гадаад улсын судалгааны их дээд сургууль, аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллага хамтарсан судалгааны зардлыг санхүүжүүлж, хэрэгжүүлэх төслийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛЬ

Тавдугаар зүйл. Судалгааны их сургуулийн бие даасан байдал.

5.1. Судалгааны их сургууль нь бие даасан байж үйл ажиллагаандаа эрдмийн эрх чөлөөг дээдэлнэ.

5.1.1. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тасралтгүй хөгжүүлнэ.

5.1.2. Судалгааны их сургуулийн хамтын удирдлагын байгууллага (Удирдах зөвлөл) хараат бус бие даасан шийдвэр гаргах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ

5.1.3. Өөрийн олсон орлогоо төсөвлөх, захиран зарцуулах эрхээ төлөөлөн удирдах байгууллагаараа шийдвэрлүүлэн бие даан зарцуулах эрхээр хангагдана.

5.1.4. Санхүүжилтийн олон эх үүсвэрүүдээс санхүүжилт авахад төрөөс баталгаа гаргуулж, дэмжлэг авна.

5.1.5. Үндэсний хэмжээний том төслүүдийг боловсруулах, түүнтэй холбоотой судалгаа шинжилгээний ажлыг засгийн газар захиалж гүйцэтгүүлэх эрхээр хангагдана.

5.1.6. Монгол Улсын язгуур эрх ашиг, аюулгүй байдал, тусгаар тогтнолын асуудлыг хөндсөн онц чухал судалгааг төр захиалж хийлгэх, тэрхүү судалгаа шинжилгээний ажлын итгэмжлэгдсэн хадгалагч байна.

5.1.7. Судалгааны их сургууль нь дэлхийн тэргүүлэх их сургуулиудтай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлнэ.

5.1.8. Энэ хууль болон бусад хуулиар тогтоосон судалгааны их сургуулийн эрх зүй, эдийн засаг, статус зэрэг бие даасан байдлын баталгааг ямар нэг хэлбэрээр дордуулсан хууль тогтоомж, захиргааны акт гаргахыг хориглоно.

5.2. Судалгааны их сургууль нь сургалтын байгууллагын хувьд Дээд боловсролын тухай хуулийн.....т заасан дээд боловсролын байгууллагад тавих нийтлэг шаардлагаас гадна дараах тусгай шаардлагуудыг хангасан байна.

5.2.1. Судалгааны их сургуулийн бүтцэд Удирдах зөвлөл, Эрдмийн зөвлөл, Захиргааны зөвлөл, бүрэлдэхүүн, салбар, харьяа сургууль, ахисан түвшний сургууль, тэнхим, эрдэм шинжилгээний хүрээлэн, төв, технологийн инкубатор, технологи дамжуулах төв, цахим мэдээллийн нэгдсэн төв, цахим номын сан ажиллана.

5.2.2. Үндсэн багшийн 60-аас доошгүй хувь нь докторын зэрэгтэй байна.

- 5.2.3. Дэлхийн тэргүүлэх их сургуулиас зочин профессор урьж ажиллуулдаг байна.
 - 5.2.4. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн байгууллагаас зарладаг судалгааны тэтгэлэгийг авч хэрэгжүүлдэг байна.
 - 5.2.5. Олон улсын хэмжээнд чадварлаг оюутныг татах хөтөлбөр, багшлах боловсон хүчинтэй байна.
 - 5.2.6. Сургалтын хөтөлбөрөө нь олон улсын магадлан итгэмжлэл хийлгэж байнга сайжруулалт хийдэг байна.
 - 5.2.7. Дэлхийн тэргүүлэх их сургуультай хамтарсан хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байна.
 - 5.2.8. Магадлан итгэмжлэгдсэн лаборатори, дундын лаборатори, тэдгээрт ажиллаж буй судлаачдын тоо, гаргаж буй эрдэм шинжилгээний үр дүнгээр тэргүүлдэг байна.
 - 5.2.9. Эрдэм шинжилгээ судалгааг дэмжих зардал нийт санхүүжилтийн 40 хувиас доошгүй байна.
 - 5.2.10. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нөлөөлөл өндөртэй мэргэжлийн сэтгүүл эрхлэн гаргадаг байна.
- 5.3. Энэ хуулийн 5.2.1-5.2.10-т заасан судалгааны их сургуульд тавих нийтлэг шаардлагыг Засгийн газар батална.
- 5.4. Судалгааны их сургуулийн бүтцийг Захиргааны зөвлөлийн саналыг үндэслэн Боловсролын ерөнхий хуулийн ... д заасан Удирдах зөвлөл батална.

6 дугаар зүйл. Судалгааны их сургуулийн чиг үүрэг.

6.1. Судалгааны их сургууль нь дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

- 6.1.1. Монгол Улсын дээд боловсрол, шинжлэх ухаан, технологийн хөгжлийг олон улсын түвшинд хүргэхэд манлайлах,
- 6.1.2. Эрдэм шинжилгээ, судалгааны үр дүнгээрээ олон улсад өрсөлдөх,
- 6.1.3. Дээд боловсрол, шинжлэх ухаан, технологийн салбарын хүний нөөцийг бүрдүүлэх, шилдэг эрдэмтэн бэлтгэх,
- 6.1.4. Шинэ мэдлэг, технологийг бүтээж үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх,
- 6.1.5. Авьяастныг татах, шилдэг суралцагч, судлаачийн хамтлагийг бүрдүүлэх,

ГУРАВДУГААР БҮЛЭГ

СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛИЙН БАГШИЙН БҮРЭН ЭРХ

7 дугаар зүйл: Багшийн эрх:

- 7.1. Судалгааны их сургуулийн багш нь дээд боловсролын тухай хуулийн 17.1.1-17.1.4-т заасан эрхээс гадна доор дурдсан эрхийг эдэлнэ.
- 7.1.1. ахисан түвшний суралцагчдыг судалгаа, сургалтын ажилд дадлагажуулах;
 - 7.1.2. удирдаж байгаа дотоод, гадаадын судалгааны төсөл хөтөлбөрийн төсвийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн захиран зарцуулах;
 - 7.1.3. судалгааны үр дүнд тохирсон цалин, урамшуулал авах.
 - 7.1.4. магистрант, докторантын судалгааны арга зүй, мэдлэг чадварыг дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор судалгааны төсөлд туслах судлаач, туслах багш ажиллуулах.

8 дугаар зүйл: Багшийн үүрэг:

8.1. Судалгааны их сургуулийн багш нь Дээд боловсролын тухай хуулийн-т зааснаас гадна дараах үүрэгтэй.

- 8.1.1. шинжлэх ухаан, техник технологийн шинэ мэдлэг, инноваци бүтээж мэдлэгийг эдийн засагжуулахад тэргүүлж ажиллах,
- 8.1.2. олон улсын түвшинд хянан магадлагаа хийгддэг эрдэм шинжилгээний мэргэжлийн сэтгүүлд бүтээлээ хэвлүүлэх;
- 8.1.3. үндэсний болон олон улсын санхүүжилт бүхий төсөл хөтөлбөр удирдах, гүйцэтгэгчээр ажиллах;
- 8.1.4. ахисан түвшний хөтөлбөрөөр суралцагчдын судалгааны ажлыг удирдах;
- 8.1.5. судалгааны ёс зүйг чандлан сахиж, оюуны өмчийн эрхийн аливаа зөрчилтэй тэмцэх, нийгмийн хариуцлагатай байх,
- 8.1.6. нийгмийг соён гэгээрүүлэх, шинжлэх ухааны мэдлэг, танин мэдэхүйг түгээн сурталчлах,

9 дүгээр зүйл: Захирлын бүрэн эрх

- 9.1. Захирал нь судалгааны их сургуулийг төлөөлж, сургуулийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулна.
- 9.2. Захирлын албан тушаалд тавих шаардлагыг боловсролын ерөнхий хууль, дээд боловсролын тухай хуулийн холбогдох заалтын дагуу боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан ажлын байрны тодорхойлолтоор тогтооно.
- 9.3. Захирал судалгааны их сургуулийн удирдлагыг Монгол Улсын хууль тогтоомж, болон өөрийн дүрэм, удирдах зөвлөлийн даргатай байгуулсан гэрээний дагуу хэрэгжүүлнэ.
- 9.4. Захирлыг 5 жилийн хугацаатайгаар Удирдах зөвлөл томилно. Нэг удаа улируулан ажиллуулж болно.
- 9.5. Захирал бүрэн эрхээ хэрэгжүүлэх, шийдвэр гаргах, захиргааны шуурхай удирдлагыг хангахад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй захиргааны зөвлөл захирлын дэргэд ажиллана.
- 9.6. Захирал судалгааны их сургуулийн санхүүжилтийг жил болгон хөндлөнгийн аудитын байгууллагаар хянуулж, олон нийтэд нээлттэй, ил тод тайлагнана.
- 9.7. Судалгааны их сургуулийн захирал Үндэсний аюулгүй байдалтай холбоотой судалгааны үр дүн, санхүүжилтийн тайланг зөвхөн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд тайлагнана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ:

СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛИЙН САНХҮҮЖИЛТ

10 дугаар зүйл. Санхүүжилтийн хэлбэр.

- 10.1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө,
- 10.2. Монгол Улсын хөгжлийн банкны хөрөнгө оруулалт,
- 10.3. Засгийн газрын бусад тусгай сангийн хөрөнгө,
- 10.4. Олон улсын хөрөнгө оруулалтын сангуудаас татах хөгжлийн албан ёсны зээл, тусламж, хандивын хөрөнгө,

- 10.5. Олон улсын санхүүгийн байгууллага, Засгийн газар хамтарсан Нийгмийн хөгжлийн чиглэлтэй бондын санхүүжилт,
- 10.6. Судалгааны их сургуулиудын дэргэд байгуулсан гарааны компаниудын хөрөнгө,
- 10.7. Судалгааны их сургуулийн өөрийн үйл ажиллагаа, хүн эмнэлэг, мал эмнэлэг, мал аж ахуйн ферм, газар тариалангийн үйл ажиллагаанаас олох орлого,
- 10.8. Сургалтын төлбөр,
- 10.9. Гадаад, дотоодын аж ахуйн нэгж, иргэдээс өгөх тусламж, хандивын хөрөнгө,
- 10.10. Судалгааны их сургуулийн эндоументийн сангийн хөрөнгө,
- 10.11. Технологи дамжуулалт, патент, ашигтай загвар, роялти, зөвлөх үйлчилгээнээс олох орлого,
- 10.12. Зээлийн хөрөнгө,
- 10.13. Инновацийн грант,
- 10.14. Хуулиар хориглоогүй бусад.

11 дүгээр зүйл. Санхүүжилтийн төлөвлөлт, зохион байгуулалт

- 11.1. Судалгааны их сургуулийг газар, барилга, байгууламж, техник, тоног төхөөрөмжөөр хангах, шинэчлэх, өргөтгөхтэй холбогдох хөрөнгө оруулалтыг бүрдүүлэх үүргийг үүсгэн байгуулагч хариуцна.
- 11.2. Энэ хуулийн 10.1, 10.2, 10.3--т заасан эх үүсвэрээс санхүүжүүлэх санхүүжилтийг буцалтгүй хэлбэрээр олгоно.
- 11.3. Улсын төсвөөс олгох санхүүжилтийн хэмжээг өмнөх жилийн эрдэм шинжилгээ, сургалтын хүрсэн үр дүнг үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.
- 11.4. Судалгааны их сургуулийн өөрийн үйл ажиллагаанаас олсон орлогоос судалгаанд зарцуулах хэмжээ, чиглэлийг тухайн их сургуулийн удирдах зөвлөл тогтооно.

12 дугаар зүйл. Гадаадын зээл, тусламж, бонд, хамтарсан үйл ажиллагааны санхүүжилтийн төлөвлөлт, зохион байгуулалт

- 12.1. Судалгааны их сургууль нь дэлхийн хөрөнгө оруулалтын сангууд, олон улсын санхүүгийн байгууллага, гадаадын засгийн газруудаас хөнгөлөлттэй зээл авах төсөл боловсруулж Боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад танилцуулна.
- 12.2. Судалгаанд шаардагдах санхүүжилтийг татвар, хураамжаас чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх санал боловсруулж боловсрол, шинжлэх ухааны асуудал болон гадаадын зээл тусламжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад танилцуулж шийдвэрлүүлнэ.
- 13.1. Захирал тухайн их сургуулийн хүлээн авсан хөнгөлөлттэй зээл, тусламжийн гэрээний үүргийн биелэлтэнд хяналт тавих, шаардлагатай мэдээллээр хангах, ил тод, нээлттэй тайлагнах үүрэг хүлээж ажиллана.

13. дүгээр зүйл. Ахисан түвшний сургалт, судалгааны тэтгэлэг

- 13.1. Ахисан түвшний оюутнууд, магистрант, докторантуудад дараах санхүүжилтийн дэмжлэг үзүүлнэ. Үүнд:
 - 13.1.1. Боловсролын хөгжлийн сангаас сургалтын зээл олгох;

- 13.1.2. Шинжлэх ухаан технологийн сангаас санхүүжүүлж байгаа төслөөс олгох судалгааны тэтгэлэг,
- 13.1.3. Хамтарсан судалгаанаас олгох судалгааны болон туслах ажилтны цалин урамшуулал;
- 13.1.4. Боловсролын хөгжлийн сан, Шинжлэх ухаан технологийн сангаас олгох тэтгэлэгийг сангуудын тусгай журмаар зохицуулна.

14 дугаар зүйл. Хамтарсан судалгааны зохион байгуулалт, санхүүжилт

- 14.1. Салбар дундын хамтын ажиллагаа судалгааг өргөжүүлэх судалгааны төсөл, тэтгэлэгийг нээлттэй зарлаж хамтран хэрэгжүүлнэ.
- 14.2. Судалгааны төслийг хамтран боловсруулах, хэрэгжүүлэхэд санхүүжилтийг судалгаанд оролцогч талууд оролцооны хувь хэмжээгээр санхүүжүүлнэ.

15 дугаар зүйл. Санхүүжилтийн дэмжлэг, урамшуулал

- 15.1. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний сэтгүүлд судалгааны ажлаа хэвлүүлсэн зохиогч, патент эзэмшигч нарт тухайн их сургууль мөнгөн урамшуулал олгож болно.
- 15.2. Энэ хуулийн 10.9-т заасан хандив өгсөн хуулийн этгээдийн өгсөн хандиваас аж ахуйн нэгжийн татвар ногдох орлогыг чөлөөлнө.

16 дугаар зүйл. Санхүүжилтийн хяналт, үнэлгээ, мониторинг

- 16.1. Энэ хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4, 10.5-т заасан эх үүсвэрүүдээс санхүүжүүлсэн хөрөнгийн зарцуулалтыг тухайн сургуулийн захирал хөндлөнгийн аудитын байгууллагаар хянуулж, олон нийтэд нээлттэй, ил тод тайлагнана.
- 16.2. Энэ хуулийн 10.6, 10.7, 10.11-д заасан санхүүжилтийн хэрэгжилт, мониторинг, тайланг компанийн тухай хуульд заасны дагуу тайлагнана.

ТАВДУГААР БҮЛЭГ

СУДАЛГААНЫ ИХ СУРГУУЛИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ

17 дугаар зүйл. Эрдэм шинжилгээ, судалгаа

- 17.1. Судалгааны их сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагаа нь төр, шинжлэх ухаан, аж үйлдвэрийн салбарын түншлэлийг бий болгож, мэдлэгт суурилсан нийгмийг хөгжүүлэхэд чиглэгдэнэ.
- 17.2. Судалгааны их сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагаа нь дараах үндсэн шаардлагад нийцсэн байна. Үүнд,
 - 17.2.1. төрөөс гаргаж буй хөгжлийн бодлого, төлөвлөлт, тэргүүлэх чиглэлтэй уялдсан байх;
 - 17.2.2. шинжлэх ухааны салбар дундын судалгааг хөгжүүлэхэд чиглэсэн байх;
 - 17.2.3. шинжлэх ухааны шинэ мэдлэг, инновацийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлдэг байх;
 - 17.2.4. шилдэг судлаачдын нэгдлийг бий болгож, бүс нутаг, олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн байх,
 - 17.2.5. санхүүжилтийн олон эх үүсвэртэй байж, тогтвортой орчин бүрдүүлсэн байх,

ЗУРГАДУГААР БҮЛЭГ
ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧИГЧДӨД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

18 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

- 18.1. Энэ хуулийг зөрчсөн иргэн, хуулийн этгээдийн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Оюуны өмчийн тухай, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд тус тус заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 18.2. Энэ хуулийг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

19 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

- 19.1. Энэ хуулийг 20.....оныдүгээр сарын-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА